

**Петро Матад Лимитед ("Петро Матад" эсвэл "Компани" гэх)
Үйл ажиллагааны шинэчилсэн мэдээлэл**

Петро Матад нь Давсан Толгой-6 цооногийг ("ДТ-6" гэх) 1,923 метрийн гүнд хүртэл өрөмдөж, Цагаанцавын формацийн доод талын галт уулын ул чулуулагт хүргэснийг мэдэгдэж байна. Өрөмдлөгийн ажил дууссан ба каротажийн бичиглэл, петрофизикийн шинжилгээ хийгдэж, цооногийн угсралт, цементлэх ажлуудыг хийж дуусгалаа. ДТ-6 цооногийн өрөмдлөгийн явцад нүүрсустөрөгч илрээгүй.

ДТ-6 цооногийг Дээд Цагаанцавын Формацийн дээд хэсгийн эртний голын хөндий дэх том хэмжээний сейсмийн аномалийн төв хэсэгт өрөмдсөн. Энэхүү аномаль нь ДТ-1 болон ДТ-2 цооногуудад тогтоогдсон тосны хуримтлалын түвшингээс 404 метрийн доор байрладаг. Геологийн даалгаварын дагуу судалгааны үндсэн хэсгийг 1,532-1,690 метрийн хооронд тогтоосон. Энэ хэсэгт агуулагч чулуулаг нь сайн чанарын агуулагч давхарга үүсгэснийг харуулсан хэдий ч нүүрсустөрөгчийн ханалт маш бага байгаа нь тогтоогдлоо. Петрофизикийн шинжилгээгээр 22 хүртэлхи хувийн нүх сүвшилтэй, ойролцоогоор 16 хувийн дундаж нүх сүвшил бүхий 33.8 орчим метрийн зузаантай агуулагч чанарын элсэн чулуу илэрсэн.

ДТ-6 цооногийн урьдчилсан үр дүн, ДТ-5 цооногийн дахин хянасан үр дүнгүүдийг 3 хэмжээст сейсмийн тайлалтай нэгтгэсэнээр дээрхи цооногуудын агуулагч давхаргын шинж чанарууд нь Дээд Цагаанцавын Формацийн дээд хэсгийн эртний голын хөндийн нүүрсустөрөгч үүсгэх систем доторхи Өвгөн голын хэтийн төлөв сайтай талбайн хувьд бидний тооцоолсон статистик хэмжээнд байгааг харуулж байна. Эртний голын хөндий дотор агуулагч болон агуулагч бус чулуулаг тархаж тогтсон байгаа нь өөр өөр тархацтай агуулагч давхарга бүхий эртний голын хөндийн хувьд хэвийн үзэгдэл юм. ДТ-5 цооногоос мэдэгдэхүйц хэмжээний нүүрсустөрөгчийн ханалт илэрсэн боловч ДТ-6 цоонгогт энэхүү үзүүлэлт хангалтгүй байсан учир Өвгөн Голын Хэтийн төлөв сайтай талбайн хураагуурын анхны загварт өөрчлөлт оруулах шаардлагатай болж байна.

Бид одоогоор Давсан Толгойн Хэтийн Төлөв Сайтай "Мод" талбайг судлахаар Давсан Толгой-7 ("ДТ-7" гэх) цооногийн байрлалыг тодорхойлж байна. Хэтийн Төлөв Сайтай "Мод" талбай нь ДТ-6 цооногоос зүүн урд зүгт 2.25 км-ийн зайд байрлах бөгөөд ДТ-6 цооногийн түвшингээс 360 метрийн өндөрт байрлах хагарал болон атираа хэлбэрийн бүтцийн хураагуур юм. ДТ-7 цооногийн геологийн үндсэн даалгавар нь Дээд Цагаанцавын дээд хэсэг болон Доод Цагаанцавын Формаци юм.

Петро Матадын Ерөнхий Гүйцэтгэх Захирал Даглас Мак Гей хэлэхдээ "ДТ-6 цооногоос нүүрсустөрөгч илрээгүй нь таагүй мэдээ хэдий ч амжилттай үр дүн үзүүлсэн манай өмнөх таван цооног болон Давсан Толгойн хэтийн төлөв сайтай талбайдын нийтлэг шинж чанараас харахад статистикийн хувьд боломжтойг харуулж байна. Бид судалгааны үр дүнтэй уялдуулан хайгуулын хөтөлбөрөө өргөжүүлэн эрчимтэйгээр үргэлжлүүлж байна. Манай хайгуулын мэргэжилтнүүд ДТ-6 болон өмнөх цооногуудын мэдээллийн тусламжтайгаар Давсан Толгойн Хэтийн Төлөв Сайтай Талбайн талаархи ойлголтоо бататгаж, дараагийн цооногуудын байрлалыг тодорхойлж байна. " гэлээ.

Энэхүү мэдээлэлд агуулагдсан техникийн мэдээллийг Компанийн Хайгуулын Менежер Доктор Жеймс Күүган хянасан болно. Доктор Күүган нь Хойд Америк, олон улсын хайгуулын болон ашиглалтын чиглэлээр 29 жил ажилласан туршлагатай газрын тосны геологич юм. Тэрээр Америкийн Газрын тосны Геологичдын Холбоо болон Америкийн Геологийн Нийгэмлэгийн гишүүн юм.

Петро Матад Лимитедийн тухай

Петро Матад нь Монгол Улсад газрын тосны хайгуул хийх, цаашид ашиглалт, үйлдвэрлэл явуулах зорилго бүхий группын толгой компани юм. Тус групп нь Монгол Улсын Засгийн газартай Бүтээгдэхүүн Хуваах гурван гэрээг дангаар байгуулан ажиллаж байна. Группын үндсэн хөрөнгө нь Монгол орны зүүн хэсэгт орших 10,340 км² талбай бүхий газрын тосны Матад ХХ талбайн Бүтээгдэхүүн Хуваах Гэрээ (“БХГ” гэх) юм. Үлдсэн хоёр талбай болох IV ба V талбайд нь Монгол орны төв хэсэгт оршдог бөгөөд хоёр талбай нийтдээ 71,040 км² талбайг хамарна.

Петро Матад Лимитед нь 1483V компанийн бүртгэлийн дугаартайгаар Мэний Аралд (Isle of Man) аралд үүсэн байгуулагдсан. Албан ёсны бүртгэлтэй төв байр нь Виктори Хаус, Проспет Хилл, Дуглас, Айл эф Мэн, Ай Эм 1, 1ИКью (Victory House, Prospect Hill, Douglas, Isle of Man, IM1 1EQ)-д байрладаг.

Нэмэлт мэдээллийг:

Петро Матад Лимитед
Ерөнхий Гүйцэтгэх Захирал – Даглас Ж. МакГей (Douglas J. McGay)
+976 11 331099

Уэстхауз Секьюритиз Лимитед
Ричард Бэти/Питр Нортон (Richard Baty/Petre Norton)
+44 (0)20 7601 6100